

Солонгост оршин суугаа гадаадын иргэдэд (12-17 насны) 3дахь тунгын  
вакцинжуулалтанд хамруулах тухай мэдээлэл

Анхан шатны вакцин хийлгээд зохих хугацаа өнгөрсөн 12-17 өсвөр насныхан дунд батлагдсан тохиолдлын тоо огцом өсөж, хүнд хэлбэрийн өвчлөл, нас баралтын тоо нэмэгдэсээр байна. Үүний улмаас өсвөр насныхныг COVID-19 халдварын улмаас хүндрэх, нас барахаас хамгаалах зорилгоор БНСУ-д оршин сууж байгаа 12-17 насны гадаадын иргэдэд COVID-19-н эрсэг вакцины 3 дахь тунг дараах байдлаар хамруулж буйг мэдэгдье.

■ Вакцинжуулалтад хамрагдах хүн

- Солонгос болон гадаадын улсад үндсэн вакцин хийлгээд 3 сар болсон 12-17 насны өсвөр насныханд хамаарах ба, өвчин хүндрэх өндөр эрсдэл бүхий бүлэгт хамрагдах хүмүүс вакцинд идэвхтэй хамрагдахыг зөвлөж байна.

※ COVID-19-ийн халдвараар өвчилж байсан өсвөр насныхан, (12-17 насны) насанд хүрэгчдийн нэгэн адилаар гурав дахь тунг хийлгэхгүй байж болно.

■ Вакцины төрөл болон тун хоорондын зай

- Өсвөр насныханд хийгдэх вакцины 3дахь тунг Pfizer вакцин хийнэ.
- 12-17 насныхан үндсэн вакцин хийлгэснээс хойш 3 сарын дараа (90 хоног) 3дахь тунгаа хийлгэх боломжтой ба дархлаа султай хүмүүст 2 сарын зайтайгаар вакцин хийнэ.  
\* Дархлаа султай хүмүүс эрүүл мэндийн байгууллагаас эмчилгээний бичиг, эмчийн магадлагаа авч харьяа эрүүл мэндийн төвдөө үзүүлснээр вакцины тун хоорондын зайнд зохицуулалт боломжтой.

■ Вакцин хийх газар болон хугацаа

- Урьдчилсан захиалгатай болон тухайн өдөрт шууд хийх вакциныг 3-р сарын 14 (Даваа) өдрөөс хийлгэж болох ба захиалгат вакциныг 3-р сарын 21 (Даваа) -аас эхлэн хийлгэх боломжтой.
- Вакциныг эрүүл мэндийн даатгалд хамрагдсан эсэхээс үл хамааран эмнэлгийн байгууллага, эрүүл мэндийн төв эсвэл COVID-19-ийн вакцинжуулалтын төвүүд дээр хийлгэх боломжтой.

■ Урьдчилсан захиалга өгөх арга

1. Солонгост үндсэн вакцин хийлгэсэн 12-17 насны гадаадын иргэд

- 1) Бүртгэлтэй гадаадын иргэн: Үндсэн вакцинжуулалтын нэгэн адил онлайн аар болон утсаар захиалгаа өгч болно.

① Онлайн захиалга: COVID-19 вакцинжуулалтын урьдчилсан захиалгын системд (<https://ncvr.kdca.go.kr>) нэвтэрч, өөртөө эсвэл төлөөлөн захиалга өгөх боломжтой.

② Утсаар захиалга хийх: Өвчнийг хянах, урьдчилан сэргийлэх газрын дуудлагын төв (☎1339) эсвэл орон нутгийн засаг захиргааны дуудлагын төвд захиалга өгөх

③ Тухайн өдөр хийлгэх вакцин: Эмнэлгийн байгууллагуудын урьдчилсан жагсаалтад(утсаар баталгаажуулах) бүртгүүлсний дараа тухайн өдөр вакцинд хамрагдах

\* SNS-ээр дамжуулан захиалах үлдэгдэл вакцины захиалгыг зөвхөн 14 ба түүнээс дээш насныхан хийх боломжтой.

- 2) Бүртгэлгүй гадаадын иргэд(хууль бусаар оршин суугаа иргэд): Үндсэн вакцинжуулалт хийлгэхдээ эрүүл

мэндийн газраас авсан түр хяналтын дугаараа ашиглан утсаар болон тарилга хийгдэж байгаа газар(эмнэлэг, эрүүл мэндийн төв) биечлэн очиж захиалга өгөх

2. Гадаадын оронд үндсэн вакцин хийлгэсэн гадаадын иргэд (90 хоногоос бага хугацаагаар оршин суух гадаадын иргэдэд ч мөн хамаарна)

- Биеийн байцаалттайгаар ойролцоох эрүүл мэндийн төв дээр очих, түр хяналтын дугаараа авч гадаад вакцин хийлгэсэн бүртгэл хийлгэсний дараа утсаар болон вакцинжуулалтын байгууллага дээр (эмнэлгийн байгууллага, эрүүл мэндийн төв) биечлэн очиж захиалгаа өгөх боломжтой.

\* Түр хяналтын дугаар олгох үед гадаад паспорт, гадаадын иргэний үнэмлэх зэрэг биеийн байцаалтыг шаардахгүй болно.

Өсвөр насныхны хувьд вакцинжуулалтын аюулгүй байдал, сөрөг харну урвалыг хянахын тулд асран хамгаалагч эсвэл хууль ёсны төлөөлөгч заавал хамт байх шаардлагатай. (Асран хамгаалагч өсвөр насны хүүхдийн хамтаар ирж, биеийн байцаалтаа шалгуулсаны дараа вакцинжуулалтын төв дээр вакцин хийлгэх маягтыг бөглөнө)

\* Асран хамгаалагч хамт ирээгүй бол тарилга хийлгэх зөвшөөрлийн хуудас, вакцин хийлгэх маягтыг урьдчилан бөглөж, тарилгад хамрагдах хүн бөглсөн хуудас маягтыг эмнэлгийн байгууллагад өгөх.

※ Жич

- Хувь хүний мэдээллийг зөвхөн вакцинжуулалтын зорилгоор ашиглах бөгөөд мэдээлэх үүргээс чөлөөлөх журмын дагуу Цагаачлалын албанд хууль бусаар оршин суугч болохыг мэдээлэхгүй болно.
- Бусад тодорхой мэдээллийг Халдварт өвчин хянах урьдчилан сэргийлэх газар Корона19 вакцинжуулалт Нүричиб (<https://ncv.kdca.go.kr>)-с шалгана уу.